



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 30 (507)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Улсын нөөцийн тухай*
- *Төмөр замын тээврийн тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Төсвийн хүрээний мэдээгдлийг зөвшөөрөх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар  
Улаанбаатар хот  
2007 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны наймдугаар сарын 14

№30 (507)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

363.	Улсын нөөцийн тухай	717
364.	Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	721
365.	Төмөр замын тээврийн тухай	721
366.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	732
367.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	733
368.	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	733
369.	Бүтээгдэхүүний загварын олон улсын бүртгэлийн Гаагийн хэлэлцээрийн 1999 оны Женевийн актад нэгдэн орсныг соёрхон батлах тухай	733

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

370.	Тогтоолын төсөл буцаах тухай	Дугаар 53	733
371.	Төсвийн хүрээний мэдэгдлийг зөвшөөрөх тухай	Дугаар 54	734

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

### УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх, захиран зарцуулах, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Улсын нөөцийн тухай хууль тогтоомж

2.1.Улсын нөөцийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Монгол Улсын

нэгдсэн төсвийн тухай хууль<sup>2</sup>, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

##### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."улсын нөөц" гэж нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах болон гамшиг, эдийн засгийн хүндрэл бэрхшээл, дайны байдал зэрэг онцгой байдлын үед энэ хууль

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль – Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

<sup>2</sup> Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль – Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 44 дүгээрт нийтлэгдсэн.

заасан зориулалт, нөхцөлийн дагуу ашиглахаар нөөцлөн хадгалж буй бараа, материалыг /цаашид "нөөцийн бараа, материал" гэх/;

3.1.2. "стратегийн нөөц" гэж нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах нэр төрөл, тоо хэмжээг нь бууруулж үл болох нөөцийн бараа, материалыг;

3.1.3. "цэргийн дайчилгааны нөөц" гэж цэргийн зориулалтаар ашиглах зэвсэг, техник, тэдгээрийн сэлбэг, нөөцийн бусад бараа, материалыг;

3.1.4. "гамшгийн нөөц" гэж гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход зориулагдах нөөцийн бараа, материалыг;

3.1.5. "нөөцийн бараа, материалыг хадгалах" гэж худалдан авсан буюу бэлтгэсэн нөөцийн бараа, материалыг зориулалтын агуулахад технологийн дагуу байршуулахыг;

3.1.6. "нөөцийн бараа, материалыг шинэчлэх" гэж нөөцийн бараа, материалыг хадгалах хугацаа, холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагын шинжилгээний дүгнэлтийг үндэслэн борлуулж, нөхөн бүрдүүлэхийг;

3.1.7. "нөөцийн бараа, материалыг сэлгэх" гэж нөөцийн бараа, материалыг агуулах, талбайд хадгалах технологийн горимыг үндэслэн шилжүүлэн байршуулахыг;

3.1.8. "улсын нөөцийн салбар" гэж нөөцийн бараа, материалыг Засгийн газраас тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээнд бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, зарцуулах, сэлгэх, шинэчлэх үүргийг холбогдох шийдвэрээр гүйцэтгэж байгуулахыг;

3.1.9. "гэрээт хадгалагч" гэж нөөцийн бараа, материалын хадгалалтын онцлог нөхцөлөөс шалтгаалан технологийн дагуу хадгалах, сэлгэн шинэчлэх үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Улсын нөөц, түүний зохицуулалт

#### 4 дүгээр зүйл. Улсын нөөц

4.1. Улсын нөөцийг стратегийн, цэргийн дайчилгааны, гамшгийн болон орон нутгийн гэж ангилна.

4.2. Орон нутгийн нөөцөд тухайн шатны Засаг дарга, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын даргын шийдвэрээр бүрдүүлэх, хадгалах, захиран зарцуулах аймаг, нийслэл, сум,

дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагад байх нөөцийг хамааруулна.

4.3. Цэргийн дайчилгааны нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, захиран зарцуулах үүргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

### 5 дугаар зүйл. Нөөцийн бараа, материалын зориулалт

5.1. Нөөцийн бараа, материалыг дараахь зориулалтаар ашиглана:

5.1.1. гамшгийн хор уршгийг арилгах;  
5.1.2. эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зах зээл дэх зарим бараа, материалын эрэлт, нийлүүлэлтийн харьцааг тэнцвэржүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5.1.3. цэргийн дайчилгааны нөөцийг Дайчилгааны тухай хуульд<sup>1</sup> заасан зориулалтаар.

### 6 дугаар зүйл. Нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх

6.1. Стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалыг Засгийн газраас тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээнд бүрдүүлэх ажлыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

6.2. Улсын нөөцөд авах бараа, материалыг чанар, аюулгүйн шаардлага хангасан тухай мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гарсан нөхцөлд хүлээн авч бүрдүүлэх, шинэчлэх арга хэмжээ авна.

6.3. Стратегийн болон цэргийн дайчилгааныхаас бусад улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар<sup>2</sup> зохицуулна.

6.4. Онцгой тохиолдолд гамшгийн болон орон нутгийн нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх асуудлыг Засгийн газар шийдвэрлэж болно.

### 7 дугаар зүйл. Нөөцийн бараа, материалыг хадгалах

7.1. Нөөцийн зарим бараа, материалыг хадгалах стандарт, технологийн шаардлага хангасан агуулах бүхий хуулийн этгээдэд /цаашид "гэрээт хадгалагч" гэх/, гэрээний үндсэн дээр

<sup>1</sup> Дайчилгааны тухай хууль – Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1998 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль – Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2005 оны 48 дугаарт нийтлэгдсэн. / 2007 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсныг "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2007 оны 8 дугаарт нийтэлсэн. /



хадгалуулж болох бөгөөд энэхүү хадгалуулах нөөцийн бараа, материалын жагсаалтыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.2.Нөөцийн бараа, материалыг хадгалах гэрээнд нөөцийн бараа, материалын чанар, стандарт, хадгалах хугацаа, төлбөр, бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ, үнэ, чанар, талуудын хүлээх хариуцлага, мэдээ тайлангийн талаар тодорхой тусгасан байна.

7.3.Стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалыг улсын нөөцийн салбар болон гэрээт хадгалагчийн агуулахад технологийн горимын дагуу хадгална.

### **8 дугаар зүйл.Нөөцийн бараа, материалыг шинэчлэх**

8.1.Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь шинэчлэх шаардлагатай стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалыг энэ хуулийн 13.1.8-д заасан журмын дагуу борлуулж, орлогоор нь нөхөн бүрдүүлнэ.

### **9 дүгээр зүйл. Нөөцийн бараа, материалын зарцуулах нөхцөл**

9.1.Нөөцийн бараа, материалыг энэ хуулийн 5.1-д заасан зориулалтын дагуу улсын нөөцөөс гаргахдаа тэдгээрийг хүлээн авах этгээдэд дараахь нөхцөлөөр олгоно:

9.1.1.улсын нөөцөд эргэн төлөгдөх нөхцөлөөр;

9.1.2.буцалтгүй тусламж болгон улсын нөөцөд эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр.

9.2.Энэ хуулийн 4.2, 4.3-т зааснаас бусад нөөцийн бараа, материалыг энэ хуулийн 9.1-д заасан нөхцөлөөр улсын нөөцөөс гаргах шийдвэрийг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар гаргана.

9.3.Засгийн газрын шийдвэрт нөөцийн бараа, материалыг хүлээн авах этгээд, нөөцийн бараа, материалыг нөхөн бүрдүүлэх хугацаа, санхүүжилтийн эх үүсвэрийг тусгасан байна.

9.4.Нөөцийн бараа, материалыг эргэн төлөгдөх нөхцөлөөр олгохдоо онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эзэлдэгчтэй гэрээ байгуулах бөгөөд гэрээнд нөөцийн бараа, материалын тоо хэмжээ, үнэ, нөхөн бүрдүүлэх хугацаа, хүлээх хариуцлага зэргийг тусгана.

9.5.Нөөцийн бараа, материалыг энэ хуулийн 5.1-д зааснаас өөр зориулалтаар улсын нөөцөөс гаргах, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй бусдад шилжүүлэх, барьцаалах, хандивлахыг хориглоно.

### **10 дугаар зүйл. Улсын төсвөөс санхүүжүүлэх зардал**

10.1.Улсын нөөцтэй холбогдсон дараахь зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

10.1.1 нөөцийн бараа, материалыг шинээр бүрдүүлэх, энэ хуулийн 9.1.2-т заасны дагуу зарцуулсан нөөцийн бараа, материалыг нөхөн бүрдүүлэх;

10.1.2 нөөцийн бараа, материалыг шинэчлэхэд гарсан үнийн зөрүүг нөхөн олгох;

10.1.3 нөөцийн бараа, материалыг тээвэрлэн байршуулах, хадгалах, хэвийн хорогдлыг нөхөхтэй холбогдон гарах зардал;

10.1.4.гэрээт хадгалагчдад нөөцийн бараа, материал хадгалуулсны төлбөр;

10.1.5.даатгалын зардал.

### **11 дүгээр зүйл. Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдалд тавих хяналт**

11.1.Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдал, стандарт, хадгалалтын технологийн мөрдөлтөд мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

11.2.Улсын нөөцийн салбар, гэрээт хадгалагч нь нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдлыг хангах дотоод хяналтын журмыг гаргаж мөрдөнө.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **Улсын нөөцийн талаархи төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх**

#### **12 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх**

12.1.Улсын Их Хурал нь улсын нөөцийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

12.1.1.улсын нөөцийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

12.1.2.стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрлийг тогтоох;

12.1.3.орон нутгийнхаас бусад улсын нөөцийн зарцуулалтын тайланг хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт өгөх.

#### **13 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

13.1.Засгийн газар нь улсын нөөцийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

13.1.1.улсын нөөцийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

13.1.2.стратегийн нөөцийн бараа, материалын байршил, тоо хэмжээг тогтоох;

13.1.3.гамшгийн нөөцийн бараа, материалын байршил, нэр төрөл, тоо хэмжээг тогтоох;

13.1.4.улсын нөөцөөс бараа, материалыг зориулалтын дагуу гаргах, нөхөн бүрдүүлэх шийдвэр гаргах;

13.1.5.энэ хуулийн 13.1.9-т заасан журмын дагуу захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх гамшгийн нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг тогтоох;

13.1.6.улсын нөөцийг санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

13.1.7.даатгалд хамрагдах бараа, материалын нэр төрөл, санхүүжилтийн хэмжээг батлах;

13.1.8.нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журмыг батлах;

13.1.9.гамшгийн нөөцөөс бараа, материал захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх журмыг батлах;

13.1.10.орон нутгийн нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

## 14 дүгээр зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

14.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн улсын нөөцийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1.нөөцийн бараа, материалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, байршил, нэр төрөл, тоо хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр болон зарцуулах, нөхөн бүрдүүлэх талаархи саналыг Засгийн газарт оруулан шийдвэрлүүлж, хэрэгжилтэд хяналт тавих;

14.1.2.энэ хуулийн 13.1.5-д заасан хэмжээнд гамшгийн нөөцийн бараа, материалыг захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх;

14.1.3.орон нутгийн нөөцийн тоо хэмжээ, нэр төрлийг тухайн шатны эрх бүхий албан тушаалтантай зөвшилцөн тогтоох.

## 15 дугаар зүйл.Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

15.1.Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.нөөцийн бараа, материалыг тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээнд бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, Засгийн газрын шийдвэрийн дагуу улсын нөөцөөс бараа, материал

гаргах, нөхөн бүрдүүлэх үйл ажиллагааг нөөцийн салбаруудаар дамжуулан хэрэгжүүлэх;

15.1.2.улсын нөөцийн салбаруудын бараа, материалын хөдөлгөөний талаархи мэдээ болон санхүүжилтийн тайланг улсын нөөцийн салбаруудаас авч нэгтгэн, улирлаар гаргаж, онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнах;

15.1.3.гэрээт хадгалагчтай гэрээ байгуулж, нөөцийн бараа, материал хадгалах үйл ажиллагаанд нь хяналт тавих;

15.1.4.улсын нөөцийн салбарт бараа, материал бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, шинэчлэх, нөхөн бүрдүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг зохион байгуулах.

## 16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

16.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1.орон нутаг дахь улсын нөөцийн салбарын үйл ажиллагааг өөрийн эрх хэмжээний хүрээнд удирдлагаар хангаж, хяналт тавих;

16.1.2.улсын нөөцийг бүрдүүлэх, сэлгэх, тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

16.1.3.орон нутгийн нөөцийг бүрдүүлэх талаар онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад санал өгөх.

## 17 дугаар зүйл. Улсын нөөцийн салбарын үүрэг

17.1.Улсын нөөцийн салбар дараахь үүрэг хүлээнэ:

17.1.1.нөөцийн бараа, материалыг тогтоосон нэр төрөл, тоо хэмжээнд нь зохих технологийн горимын дагуу хадгалах, хамгаалах;

17.1.2.онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг үндэслэн нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, зарцуулах, сэлгэх, шинэчлэх, тээвэрлэж хүргэх үйл ажиллагааг эрхлэх;

17.1.3.нөөцийн бараа, материалын үлдэгдэл, зарцуулалтын мэдээ, санхүүжилтийн тайланг сар, улирлаар гаргаж, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнах;

17.1.4.нөөцийн бараа, материалыг зарцуулах, бүрдүүлэхийн өмнө болон хадгалалтын явцад жилд 1-2 удаа чанар, стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангаж байгаа эсэх талаар мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг гаргуулж, холбогдох арга хэмжээ авах;

17.1.5.нөөцийн бараа, материалыг хадгалах барилга, байгууламж, агуулахын нөхцөл байдалд чанар, стандарт, эрүүл ахуй болон



ургамал хорио цээрийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг гаргуулсан байх.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Бусад зүйл.

**18 дугаар зүйл. Улсын нөөцийг бүрдүүлэх, хадгалахтай холбогдуулан гэрээ байгуулсан этгээдийн хүлээх эд хөрөнгийн хариуцлага**

18.1. Нөөцийн бараа, материал нийлүүлэх болон эргэн төлөгдөх нөхцөлөөр авах хуулийн этгээд, гэрээт хадгалагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол энэ хууль болон тухайн гэрээнд заасан хариуцлага хүлээнэ.

18.2. Гэрээнд хариуцлага хүлээлгэх дор дурдсан нөхцөлийг заавал тусгасан байна:

18.2.1. нөөцийн бараа, материалыг заасан хугацаанд нийлүүлээгүй бол;

18.2.2. нөөцийн бараа, материалыг дутуу нийлүүлсэн бол;

18.2.3. стандартын шаардлагыг хангаагүй бараа, материал нийлүүлсэн бол;

18.2.4. нөөцийн бараа, материалын сав, баглаа, боодол нь гэмтсэн буюу шаардлага хангаагүй бол;

18.2.5. нөөцийн бараа, материалыг эргэн төлөгдөх хугацаанд нь нийлүүлээгүй бол;

18.2.6. нөөцийн бараа, материалыг үрэгдүүлсэн, чанар байдлыг нь муутгасан бол;

18.2.7. талууд тохиролцон гэрээнд тусгасан бусад нөхцөл зөрчигдсөн бол.

**19 дүгээр зүйл. Улсын нөөцийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

19.1. Улсын нөөцийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч зөрчил гаргасан этгээдэд дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:

19.1.1. энэ хуулийн 9.5-д заасныг зөрчсөн бол зөрчил гаргасан албан тушаалтанг 100000-200000 төгрөгөөр, байгууллагыг 300000-500000 төгрөгөөр тус тус торгож, дур мэдэн зарцуулсан нөөцийн бараа, материалын үнийн дүнг нөхөн төлүүлэх;

19.1.2. энэ хуулийн 17, 18.2-д заасныг зөрчсөн бол зөрчил гаргасан албан тушаалтныг 200000-300000 төгрөгөөр торгож, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;

19.1.3. хариуцсан нөөцийн бараа, материалын талаар санаатайгаар буруу мэдээлсэн буюу хуурамч тайлан мэдээ гаргаж өгсөн бол зөрчил гаргасан албан тушаалтныг 100000-200000 төгрөгөөр торгох.

## МОНГОЛ УЛСЫН

### ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

### ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.

тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Улсын нөөцийн

## МОНГОЛ УЛСЫН

### ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж,

хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж**

2.1. Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, энэ

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "төмөр замын объект" гэж төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зурвас газар, суурь бүтэц, дагнасан хэрэглээний зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн болон бусад тоног төхөөрөмж, эд хөрөнгийг;

3.1.2. "суурь бүтэц" гэж төмөр замын шугамын дээд, доод бүтэц болон гүүр, хоолой зэрэг инженерийн байгууламж, өртөө, зөрлөг, галт тэрэгний хөдөлгөөний хэвийн үйл ажиллагааг хангах эрчим хүч, усан хангамж, дохиолол холбоо, мэдээллийн барилга байгууламж, гарам, хориг хашаа зэрэг техник технологийн иж бүрдлийг;

3.1.3. "төмөр замын шугам" гэж төмөр замын өртөө хоорондын зам болон өртөөн дэх түүний шууд үргэлжлэлийг;

3.1.4. "хөдлөх бүрэлдэхүүн" гэж зүтгүүр, вагон, түүнчлэн төмөр замаар явдаг бусад техникийг;

3.1.5. "салбар зам" гэж сэлгээний болон ачих, буулгах ажил хийх зориулалтаар төмөр замын шугам болон өртөөний замаас салбарлаж тавьсан замыг;

3.1.6. "нийтийн хэрэглээний зам" гэж төмөр замын шугам, өртөөнд галт тэрэг хүлээж авах, явуулах, ялгах болон сэлгээний ажил гүйцэтгэх, ачаа, ачаан тээш хүлээн авах, олгох, зорчигчдод үйлчлэх зам, түүнчлэн нийтэд үйлчлэх зориулалттай бусад салбар замыг;

3.1.7. "нийтийн хэрэглээний талбай" гэж зорчигчийн тавцан болон үйлчлүүлэгчийн ачаа, тээш, ачаан тээшийг ачих, буулгах, ялгах, хадгалах зориулалтаар нийтэд үйлчлэхээр тусгайлан гаргасан агуулах, талбайг;

3.1.8. "дагнасан хэрэглээний зам" гэж эзэмшигчийн өөрийн хэрэгцээг хангах буюу гэрээний үндсэн дээр тодорхой хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэхэд зориулагдсан салбар замыг;

3.1.9. "дагнасан хэрэглээний талбай" гэж үйлчлүүлэгчийн ачаа, тээш, ачаан тээшийг ачих, буулгах, ялгах, хадгалах зориулалтаар тусгайлан гаргасан агуулах, талбайг;

3.1.10. "төмөр замын гарам" гэж авто болон явган хүний зам төмөр замтай нэг түвшинд огтлолцсоныг;

3.1.11. "төмөр замын зурвас газар" гэж төмөр замын шугамын дагуух технологийн онцлог үйл ажиллагааг явуулах, тээврийн аюулгүй байдлыг хангах зориулалт бүхий газрыг;

3.1.12. "төмөр замын аюултай бус" гэж галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, ачилт, буулгалтын ажил гүйцэтгэдэг дэвсгэр газрыг;

3.1.13. "төмөр замын аюулгүйн бус" гэж төмөр зам дээр тохиолдож болох осол, сүйрлээс хуулийн этгээд, иргэнд учрах хохирлыг багасгах, аюулгүй нөхцөлийг хангах зориулалт бүхий газрыг;

3.1.14. "овор" гэж хөдөлгөөний аюулгүй байдал, аюулгүйн техникийн шаардлагын дагуу төмөр замын объект, хөдлөх бүрэлдэхүүн, төмөр замын ойролцоох барилга байгууламж, ачаа байршлын зайн хязгаарыг тогтоосон хэмжээг;

3.1.15. "төмөр замын байгууллага" гэж суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийг;

3.1.16. "суурь бүтэц эзэмшигч" гэж суурь бүтцийг өмчлөх буюу эзэмших эрхтэй, суурь бүтэц ашиглах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

3.1.17. "тээвэрлэгч" гэж төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

3.1.18. "нийтийн хэрэглээний зам эзэмшигч" гэж эзэмшилдээ нийтийн хэрэглээний замтай хуулийн этгээдийг;

3.1.19. "нийтийн хэрэглээний талбай эзэмшигч" гэж эзэмшилдээ нийтийн хэрэглээний талбай бүхий хуулийн этгээдийг;

3.1.20. "дагнасан хэрэглээний зам эзэмшигч" гэж эзэмшилдээ дагнасан хэрэглээний замтай хуулийн этгээдийг;

3.1.21. "дагнасан хэрэглээний талбай эзэмшигч" гэж эзэмшилдээ дагнасан хэрэглээний талбай бүхий хуулийн этгээдийг;

3.1.22. "дайвар үйлчлүүлэгч" гэж бусдын эзэмшлийн нийтийн болон дагнасан хэрэглээний замд өөрийн эзэмшлийн агуулах, талбайтай, эсхүл өртөө, зөрлөгийн замд өөр салбар замаар дамжин холбогдож буй нийтийн буюу дагнасан хэрэглээний зам бүхий иргэн, хуулийн этгээдийг;

3.1.23. "төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа" гэж ачаа, тээш, ачаан тээш, чингэлгийг тээвэрлэхэд бэлтгэх, хүлээн авах, ачих, тээвэрлэх, буулгах, хүлээлгэн өгөх болон зорчигч тээвэрлэх, сэлгээний ажил гүйцэтгэх үеийн зохион байгуулалт, технологийн харилцан уялдаатай цогцолбор ажил, үйлчилгээг;

3.1.24. "суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмаг" гэж суурь бүтцийн хүрээнд галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах төлөвлөлтийн баримт бичгийг;

3.1.25. "хөдөлгөөний нэгдсэн зурмаг" гэж Монгол Улсын нийт суурь бүтцүүдийн хүрээнд галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах төлөвлөлтийн баримт бичгийг;

3.1.26. "хатуу төсөөрт багаж, хэрэгсэл" гэж хяналт, бүртгэлгүйгээр ашиглах нь төмөр замын тээврийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй ашиглах, хүлээлцэх тусгай

журам бүхий төмөр замын засвар, үйлчилгээний багаж, хэрэгслийг.

#### 4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1 Энэ хуулиар өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр төмөр замын тээврийн бүх төрлийн үйл ажиллагааг зохицуулна.

#### 5 дугаар зүйл. Төмөр замын тээврийн үйл ажиллагааны үндсэн зарчим

5.1. Төмөр замын тээврийн үйл ажиллагаанд дор дурдсан зарчмыг баримтална:

5.1.1. зурмагийн нэгдмэл зохицуулалттай байх;

5.1.2. байнгын хяналттай байх;

5.1.3. үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг хангах;

5.1.4. тасралтгүй үйл ажиллагааг хангах;

5.1.5. зах зээлийн өрсөлдөөнт нөхцөлийг бий болгох;

5.1.6. тээврийн бусад салбарын үйл ажиллагаатай уялдуулах.

5.2. Төрөөс төмөр замын тээврийн үйл ажиллагааг хянан зохицуулж, төмөр замын тээврийг хөгжүүлэхэд оролцоно.

#### 6 дугаар зүйл. Төмөр замын объектын омчлол

6.1. Төмөр замын зурвас газар нь төрийн өмч байна.

6.2. Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтцийг төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байхаар, эсхүл түүний өмчлөлд ашиглалтын тодорхой хугацааны дараа шилжүүлэх нөхцөлөөр шинээр байгуулж болох бөгөөд эдгээр суурь бүтэц, төмөр замын шугамын чигийг Засгийн газар тогтооно.

6.3. Төмөр замын зурвас газар болон улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтэцээс бусад төмөр замын объект, салбар болон дагнасан хэрэглээний зам нь өмчийн аль ч төрөл, холбэрийн байж болно.

6.4. Ашиглалтын тодорхой хугацааны дараа суурь бүтцийн тодорхой хувийг энэ хуулийн 6.2-д заасны дагуу төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдэд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг суурь бүтэц эзэмшигчтэй тохиролцож, суурь бүтэц барих, ашиглах тусгай зөвшөөрөлд тусгана.

#### 7 дугаар зүйл. Төмөр замын тээврийн тариф, хөлс

7.1. Төмөр замын байгууллага нь зүй ёсны монополи болон зах зээл дээр давамгайлсан ажил, үйлчилгээтэй холбоотой төмөр замын тээврийн үйлчилгээний хөлс, тарифыг энэ хууль болон Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай<sup>1</sup> хуульд нийцүүлэн тогтооно.

7.2. Төмөр замын олон улсын тээвэрлэлтийн тарифыг Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн тогтооно.

7.3. Тарифын өөрчлөлтийг хүчин төгөлдөр болохоос 10-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

#### ХОЁРДУГААР БҮЛЭГ

##### Төмөр замын тээврийн талаархи төрийн зохицуулалт

#### 8 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

8.1. Улсын Их Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. төмөр замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлого тодорхойлох;

8.1.2. төмөр замын тээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах;

8.1.3. төмөр замын тээврийн талаархи олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох, гарах асуудлыг шийдвэрлэх.

#### 9 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

9.1. Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. төмөр замын тээврийн талаархи төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

9.1.2. суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох, цуцлах;

9.1.3. төмөр замын байгууллагад ашиглуулах зурвас газрын хэмжээ, хугацаа, нөхцөлийг тогтоох;

9.1.4. төмөр замын зурвас газар эзэмшигчийг газрын төлбөрөөс хөнгөлөх асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх;

9.1.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

<sup>1</sup> Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2000 оны 20 дугаарт нийтлэгдсэн.



**10 дугаар зүйл. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

10.1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1. төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийг батлах;

10.1.2. төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журмыг Тагнуулын ерөнхий газартай хамтран батлах;

10.1.3. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, гадаад улсын төрийн эргүүн зэрэг төрийн өндөр албан тушаалтны зорчих тусгай галт тэрэгний аялах журмыг Тагнуулын ерөнхий газартай зөвшилцөн батлах;

10.1.4. төмөр замын техникийн осол, сүйрлийг шинжлэн далгах ерөнхий шинжээчийг томилох;

10.1.5. төмөр замын олон улсын хамтын ажиллагаанд Монгол Улсыг төлөөлөх;

10.1.5. зарим төрлийн /зорчигч, шуудан, улс орны эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой зчааны г.м./ тээвэрлэлтэд давуу байдал олгох;

10.1.7. тусгай тээвэрлэлт болон цэргийн тээвэрлэлт гүйцэтгэх журмыг эрх бүхий байгууллагатай зөвшилцөн батлах;

10.1.3. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

10.2. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 10.1.2, 10.1.4, 10.1.5, 10.1.7-д заасан бүрэн эрхээс бүрэн буюу хэсэгчлэн төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад иилжүүлж болно.

**11 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарын бүрэн эрх**

11.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1. төмөр замын зурвас газар, объект, өртөг, буудалд нийгмийн хэв журам сахиулах ажлыг төмөр замын байгууллагатай хамтран зохион байгуулах;

11.1.2. хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төмөр замын хөдөлгөөнтэй шууд холбоотой албан тушаалд ээлжээр ажилладаг ажилтныг цэргийн албанд татахаас бусад дайчилгаанд хямааруулахгүй байх;

11.1.3. байгалийн гамшиг, сүйрэл, ослын хор уршгийг арилгах, төмөр замын байгууллагын эсрэгтгүй, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдх мод, хайрга, чулуу, элс, ус зэргийг хууль тогтоомжийн дагуу олгох;

11.1.4. шаардлагатай бол байгалийн гамшиг, төмөр замын сүйрэл, осол, гологдлын хор уршгийг арилгах болон аюулгүй байдлыг хангахад нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс тоног төхөөрөмжийг нөхөн олговортойгоор гаргуулах, хүн хүчний туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах.

**12 дугаар зүйл. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний бүрэн эрх**

12.1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "төрийн захиргааны байгууллага" гэх/ нь төмөр замын тээврийн салбарт Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй, өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжих зарчмаар ажиллах Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

12.2. Төрийн захиргааны байгууллагын харьяанд төмөр замын тээврийн хяналтын алба, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв ажиллана.

12.3. Төрийн захиргааны байгууллага нь дэргэдээ сургалт, судалгаа шинжилгээний байгууллагатай байж болно.

12.4. Төрийн захиргааны байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.4.1. төмөр замын тээврийн талаархи хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах;

12.4.2. төмөр замын тээврийн салбар дахь төрийн өмчийн ашиглалт болон төрийн захиалгаар хийгдэх тээвэрлэлтэй холбоотой үйл ажиллагаанд төрийн төлөөллийг хууль, олон улсын гэрээнд заасны дагуу хэрэгжүүлэх;

12.4.3. төмөр замын тээврийн салбарт шударга бус өрсөлдөөн үүсэхээс сэргийлэх зорилгоор тариф, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ, гэрээний өөрчлөлтийг хянаж, санал, дүгнэлт гаргах;

12.4.4. суурь бүтэц ашиглах, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх болон суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

12.4.5. төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

12.4.6. төмөр замын объект, салбар замыг өргөтгөх, шинээр барих ажиллагаанд хяналт тавих;

12.4.7. үйл ажиллагааны орлогын тодорхой хэсгийг төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангуулахад зарцуулах;

12.4.8. төмөр замын тээврийн салбарт мөрдөх улсын стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах;

12.4.9. төмөр замын мэргэжлийн ажилтан ажиллах албан тушаалын жагсаалт, галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажил, албан тушаалын жагсаалтыг батлах;

12.4.10. төмөр замын тээврийн салбарын статистик, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хөтлөх;

12.4.11. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## 13 дугаар зүйл. Төмөр замын тээврийн хяналтын алба, түүний бүрэн эрх

13.1. Төмөр замын тээврийн хяналтын алба /цаашид "хяналтын алба" гэх/ нь төмөр замын тээврийн аюулгүй байдла, үйлчилгээний чанар, хөдөлмөр хамгаалаа, аюулгүй ажиллагаанд тавих захиргааны хяналтыг хэрэгжүүлнэ.

13.2. Хяналтын алба нь улсын ахлах байцаагч, улсын байцаагчаас бүрдэнэ.

13.3. Улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг төрийн захиргааны байгууллагын даргын санал болгосноор мэргэжлийн хяналтын улсын ерөнхий байцаагч олгоно.

13.4. Төмөр замын тээврийн улсын ахлах байцаагч нь хяналтын албаны дарга байна.

13.5. Хяналтын алба нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.5.1. төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулахтай холбогдсон хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх үндсэн дээр гаргасан бусад шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

13.5.2. төмөр замын тээвэрт ашиглаж буй техник, төхөөрөмж, байгууламж болон төмөр замын тээвэртэй холбоотой ажил, үйлчилгээ, технологийн горим нь төмөр замын тээврийн аюулгүй байдал, стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг өмчийн хэлбэр, байршил харгалзахгүйгээр шалгах;

13.5.3. галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдлыг хянаж, сүйрэл, осол, гологдол гарах нөхцөл бий болсон үед төмөр замын объектын ашиглалтыг хязгаарлах, түр зогсоох;

13.5.4. төмөр замын тээвэрт гарсан сүйрэл, осол, гологдлын шалтгааныг судалж, мэргэжлийн дүгнэлт гаргах, арга хэмжээ авах;

13.5.5. тусгай зөвшөөрөл, гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар эрх бүхий байгууллагад санал оруулах;

13.5.6. ачаа, чингэлэг, ачаан тээш, тээшний жин болон тээврийн бичиг баримт, түүнтэй холбогдох бусад мэдээллийг шалгах;

13.5.7. хяналтын албаны эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа төмөр замын тээвэрт ашиглаж байгаа барилга байгууламж, хөдлөх бүрэлдэхүүнд чөлөөтэй нэвтрэх, зорчих;

13.5.8. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

13.6. Хяналтын албаны ажилтнууд тусгай дүрэмт хувцас хэрэглэнэ.

## 14 дүгээр зүйл. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, түүний чиг үүрэг, бүрэн эрх

14.1. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв /цаашид "хөдөлгөөн зохицуулалтын төв" гэх/ нь төмөр замын байгууллагуудын галт тэрэгний хөдөлгөөнийг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэй.

14.2. Хөдөлгөөн зохицуулалтын төвийн ажиллах журмыг төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр тодорхойлно.

14.3. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төв нь дараахь бүрэн эрхтэй:

14.3.1. хөдөлгөөний нэгдсэн зурмагийг батлах;

14.3.2. хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд суурь бүтцүүдийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулж, зохицуулалт хийж;

14.3.3. суурь бүтэц эзэмшигч хоорондын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын харилцан уялдааг хангах;

14.3.4. галт тэрэгний хөдөлгөөний удирдлагатай холбоотой санал, дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх;

14.3.5. галт тэрэгний хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн суурь бүтэц эзэмшигчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

14.3.6. тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горимыг боловсруулах;

14.3.7. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## 15 дугаар зүйл. Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм

15.1. Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр дараахь журмыг тогтооно.

15.1.1. төмөр замын техник ашиглалтын журам;

15.1.2. төмөр замын дохиолол холбооны журам;

15.1.3. галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам;

15.1.4. төмөр замын тээвэр дэх осол, гологдлыг судлан бүртгэх журам;

15.1.5. төмөр замаар ачаа тээвэрлэх журам;

15.1.6. төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх журам;

15.1.7. төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааны журам;

15.1.8. галт тэрэгний зурмаг зохицуулалтын журам;

15.1.9. суурь бүтэц ашиглуулах журам, тариф тогтоох аргачлал;

15.1.10. төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам;

15.1.11. төмөр замын аюултай бус, төмөр замын зурвас газар, аюулгүйн бүсэд төмөр замын болон бусад объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх журам;

15.1.12. Монгол Улсын хилээр нэвтрэх буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам;

15.1.13. галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилгын тусгай журам, ажлын цагийн хуваарь, хөдөлмөрийн нөхцөл;

15.1.14. холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталсан төмөр замын мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, сургалт явуулах, мэргэжлийн шалгалт авах журам;

15.1.15. суурь бүтэц, нийтийн болон дагнасан хэрэглээний зам ашиглах, суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч хоорондын хамтран ажиллах болон тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх гэрээний үлгэрчилсэн загвар;

15.1.16. төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам.

## 16 дугаар зүйл. Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл

16.1. Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл /цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/ дараахь төрөлтэй байна:

16.1.1. суурь бүтэц барих, ашиглах;

16.1.2. суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах;

16.1.3. төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх.

16.2. Тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай<sup>3</sup> хуулийн 11 дүгээр зүйлд

зааснаас гадна дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ:

16.2.1. техник, эдийн засгийн урьдчилсан үндэслэл;

16.2.2. эзэмшилдээ байгаа төмөр замын объект, үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрөл, гэрчилгээний нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар.

16.3. Суурь бүтэц барих, ашиглах тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргахдаа энэ хуулийн 16.2-т зааснаас гадна дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

16.3.1. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

16.3.2. хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр;

16.3.3. үйл ажиллагаа эхлэх хугацаа, эзэмшилд байх газрын зааг.

16.4. Төрийн захиргааны байгууллага өргөдлийг хүлээн авч дараахь нөхцөл байдлыг шалгана:

16.4.1. төмөр замын тухай хууль тогтоомж, стандарт, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийн хэрэгжилт, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангасан эсэх;

16.4.2. дотооддоо үйлчлэх техник, технологийн дүрэм, зааврын бүрдлийг хангасан эсэх;

16.4.3. тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадвартай эсэх.

16.5. Суурь бүтэц барих, ашиглах тусгай зөвшөөрлийг хянан шийдвэрлэх үед холбогдох төрийн захиргааны төв байгууллага дараахь нөхцөл байдлыг шалгаж, дүгнэлт гаргана:

16.5.1. улс орныг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхолд харшлах нөхцөл байдал байгаа эсэх;

16.5.2. эзэмшилд олгох газар нь улсын тусгай хэрэгцээний буюу бусдын эзэмшлийн газартай давхцаж байгаа эсэх;

16.5.3. байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах эсэх;

16.5.4. Засгийн газрын үүрэг болгосон холбогдох бусад асуудал.

16.6. Өргөдөл гаргагч өргөдөл гаргасны дараа тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг

<sup>3</sup> Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль - Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

биелүүлэх, баримт бичгийн иж бүрдлийг хангах болон бусад асуудлаар өргөдөл хянан үзэх ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулах хүсэлт гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд энэ хуулийн 16.9-д заасан хугацааг баримт бичгийн иж бүрдлийг хангасан үеэс эхлэн тоолно.

16.7. Төрийн захиргааны байгууллага нь суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг нягтлан шалгаад дүгнэлт, суурь бүтэц ашиглах, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянан үзэж тусгай зөвшөөрөл олгох, эсхүл олгохоос татгалзсан тухай шийдвэрийн аль нэгийг нь гаргана.

16.8. Төрийн захиргааны байгууллага нь суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох баримтыг 14 хоногийн дотор хянаж, дүгнэлтийн хамт төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

16.9. Эрх бүхий байгууллага нь суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох асуудлыг 45 хоногийн дотор, суурь бүтэц ашиглах, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлыг 21 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл энэ хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болно.

16.10. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай өргөдлийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 21 хоногийн өмнө гаргаж, эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах эсэх асуудлыг 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

16.11. Тусгай зөвшөөрөл олгох, эсхүл олгохоос татгалзсан шийдвэрийг хуульд заасан хугацаанд багтаан бичгээр хариу өгнө.

## 17 дугаар зүйл. Төмөр замын тээврийн салбар дахь стандартчилал

17.1. Төмөр замын тээврийн салбарт баримтлах стандартыг энэ хууль болон стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн дагуу боловсруулан баталж, мөрдүүлнэ.

17.2. Хууль тогтоомж, үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн эрх ашигт харшлахгүй, үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулахгүй бол төрийн захиргааны байгууллага нь олон улс, гадаад улсын дэвшилтэй стандартыг эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр хэрэглэж болно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага, иргэн, тэдгээрийн эрх, үүрэг

#### 18 дугаар зүйл. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага, иргэн

18.1. "Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч" гэдэгт төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангаж, төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэмд заасны дагуу тээвэрлэлтийг зохион байгуулах үүрэг бүхий суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хамаарна.

18.2. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагатай энэ хуулийн 15.2.15-д заасан загвараар гэрээ байгуулж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэмд заасны дагуу үүрэг, үйл ажиллагаа явуулах хүрээг зааглан тодорхойлох арга хэмжээ авна.

18.3. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч дор дурдсан нийтлэг эрхтэй байна:

18.3.1. төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх үндсэн дээр гаргасан шийдвэрийн дагуу төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх;

18.3.2. хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, бусад дүрэм, стандартыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дотооддоо үйлчлэх техник, технологийн дүрэм, журам, зааврыг баталж, мөрдүүлэх;

18.3.3. төмөр замын тээврийн үйлчилгээний үнэ, тарифыг улс орны эдийн засгийн тогтвортой хөгжил, хэрэглэгчийн ашиг сонирхлыг харгалзан энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу тогтоож, мөрдөх;

18.3.4. хууль тогтоомжид заасан бусад эрх.

18.4. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь дор дурдсан нийтлэг үүрэгтэй байна:

18.4.1. тусгай зөвшөөрөл, гэрчилгээтэй байх;

18.4.2. төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай мэргэжлийн ажилтантай байх;

18.4.3. төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм болон холбогдох бусад дүрэм, стандартыг дагаж мөрдөх;

18.4.4. төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн галт тэрэгний хөдөлгөөний



удирдлагатай холбоотой захирамжлалыг биелүүлэх;

18.4.5. эзэмшигч буй төмөр замын объектын тасралтгүй, хэвийн ажиллагааг хангах, тэдгээрийн бүртгэлийг хөтөлж, тогтоосон журам, технологийн дагуу үзлэг, үйлчилгээ хийх;

18.4.6. үйл ажиллагааны орлогын тодорхой хэсгийг төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангахад зарцуулах;

18.4.7. төмөр замын тээвэртэй холбоотой үйл ажиллагааны талаар төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэмд заасны дагуу холбогдох төрийн захиргааны байгууллагад мэдээ, тайлан гаргаж өгөх;

18.4.8. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

18.5. Тээвэрлэлтэд оролцогчийн тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг Иргэний хууль<sup>4</sup>, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм болон холбогдох бусад эрх зүйн актаар зохицуулна.

## 19 дүгээр зүйл. Суурь бүтэц эзэмшигчийн эрх, үүрэг

19.1. Суурь бүтэц эзэмшигч нь дараахь эрхтэй:

19.1.1. суурь бүтцийг өөрөө ашиглах буюу гэрээний үндсэн дээр тээвэрлэгчид ашиглуулах;

19.1.2. суурь бүтэц ашиглуулсны төлбөр болон гэрээнд заасан бусад засвар, үйлчилгээний хөлс авах;

19.1.3. суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийг тогтоосон журмаар батлах, хөдөлгөөний нэгдсэн зурмагт санал өгөх;

19.1.4. хууль тогтоомжид заасан бусад эрх.

19.2. Суурь бүтэц эзэмшигч нь дараахь үүрэгтэй:

19.2.1. өөрийн эзэмшлийн суурь бүтцийн техникийн аюулгүй байдлыг хангаж, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

19.2.2. хөдөлгөөний нэгдсэн зурмаг болон суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн дагуу өөрийн эзэмшлийн суурь бүтцийн үйлчилгээний хүрээнд галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулах, хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэх;

19.2.3. суурь бүтцийн нэвтрүүлэх хүчин чадлыг харгалзан тээвэрлэгч, түүний дотор өөрийн харъяаллын буюу өөрийн хөрөнгө оруулалттай тээвэрлэгчтэй суурь бүтэц ашиглалтын гэрээг ижил нөхцөлөөр байгуулж, тээвэрлэлт хийх нөхцөлийг бүрдүүлэх;

19.2.4. суурь бүтцийн үйлчлэлийн хүрээнд дагнасан хэрэглээний зам эзэмшигчидтэй

гэрээ байгуулж, галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулах арга хэмжээ авах;

19.2.5. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

19.3. Суурь бүтэц эзэмшигч тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа тохиолдолд суурь бүтэц болон тээвэрлэлтийн үйл ажиллагааны санхүүгийн тооцоо тусдаа байна.

19.4. Суурь бүтэц эзэмшигч нь төмөр замын объект, тээвэрлэгч байгаа ачаа, тээш, ачаан тээшийг гэмт халдлагаас хамгаалах үүрэг бүхий харуул хамгаалалтын болон хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийн биелэлт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий дотоод хяналтын албатай байна.

## 20 дугаар зүйл. Тээвэрлэгчийн эрх, үүрэг

20.1. Тээвэрлэгч дараахь эрхтэй:

20.1.1. гэрээний дагуу суурь бүтэц, дагнасан хэрэглээний зам, хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглах;

20.1.2. захиалга, гэрээний дагуу өөрөө буюу бусад тээвэрлэгчээр дамжуулан тээвэрлэлтийг хэрэгжүүлэх;

20.1.3. гэрээгээр тохирсон үйлчилгээний хөлс авах;

20.1.4. хууль тогтоомжид заасан бусад эрх.

20.2. Тээвэрлэгч дараахь үүрэгтэй:

20.2.1. шударга бус өрсөлдөөн гаргахгүй байх зорилгоор тээвэрлүүлэгчдэд, тэдгээрийн дотор өөрийн шууд харъяаллын байгууллагад тээвэрлэлтийн илүү хөнгөлттэй нөхцөл олгохгүй байх;

20.2.2. эзэмшилдээ байгаа хөдлөх бүрэлдэхүүний техникийн болон ашиглалтын аюулгүй байдлыг хангах;

20.2.3. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

20.3. Тээвэрлэгч нь хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэмд зааснаас бусад үндэслэлээр үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг хориглоно.

## 21 дүгээр зүйл. Нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч

21.1. Нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч нь суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч болон дайвар үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулж өөрийн зам, талбайд ачаа, ачаан тээш, вагон, чингэлгийг тээвэрлэлтэд бэлтгэх, ачих, буулгах, хадгалах үйлчилгээ үзүүлнэ.

<sup>4</sup> Иргэний хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.



21.2. Нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбайг ашиглахтай холбоотой харилцааг төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр зохицуулна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Төмөр замын объект

22 дугаар зүйл. Төмөр замын объектод тавигдах үндсэн шаардлага

22.1. Суурь бүтэц, дагнасан хэрэглээний зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн болон төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой бусад төхөөрөмж, байгууламж нь төмөр замын хөдөлгөөний болон техникийн аюулгүй ажиллагаа, технологийн горим, стандарт, шаардлагад нийцсэн байна.

23 дугаар зүйл. Суурь бүтцийг барьж байгуулах, шинэчлэх

23.1. Суурь бүтцийг барих, сайжруулах үйл ажиллагааг суурь бүтэц эзэмшигчийн болон улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, түүнчлэн хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

23.2. Улсын болон аймгийн зэрэглэлтэй хотуудыг холбосон төмөр замын шугам шинээр барихад улсын буюу тухайн орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалт хийж болно.

23.3. Энэ хуулийн 23.2-т заасан төмөр замын шугам барих үйл ажиллагаанд Засгийн газар, тухайн орон нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, түүнчлэн холбогдох бусад байгууллага бүх талаар дэмжлэг үзүүлнэ.

23.4. Энэ хуулийн 23.2, 23.3-т заасан хөрөнгө оруулалтын болон эрх бүхий байгууллагын дэмжлэг авахдаа шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийг баримтална.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Төмөр замын тээврийн аюулгүй байдлын үндсэн шаардлага

24 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа

24.1. Төмөр замын тээврийн аюулгүй байдал нь төмөр замын болон бусад байгууллага, иргэдийн дараахь үйл ажиллагаагаар хангагдана:

24.1.1. зорчигчийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх;

24.1.2. хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;

24.1.3. ачаа, тээш, ачаан тээшийг бүрэн бүтэн тээвэрлэх;

24.1.4. төмөр замын байгууллагын ажилтанд тавих аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах;

24.1.5. хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх.

25 дугаар зүйл. Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах ажлын зохион байгуулалт

25.1. Төмөр замын байгууллага, түүний салбар нэгж, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигчийн галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний технологийн хэвийн ажиллагааг хөдөлгөөний нэгдсэн зурмаг, суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагаар зохицуулах бөгөөд тэдгээрийг энэ хуульд нийцүүлэн тогтоосон журмын дагуу эрх бүхий байгууллагын дарга батална.

25.2. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс нийлүүлэгч нь галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой суурь бүтцийн эрчим хүчний хангалтыг тасалдуулахгүй байх арга хэмжээ авна.

25.3. Зорчигч, тээш тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор зорчигчийн галт тэргийг өртөө, зөрлөгт зөвхөн зориулалтын замаар хүлээн авч явуулах бөгөөд зорчигчийн галт тэргийг хүлээн авах, явуулах зориулалтын зам нь стандарт, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр тогтоосон хэмжээний гэрэлтүүлэг, тавцан, талбайтай байна.

25.4. Төмөр замын байгууллага, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч нь тэмдэг, дугаар бүхий хатуу тооцоот багаж, хэрэгсэлтэй байх бөгөөд түүний жагсаалт, ашиглах болон хүлээлцэх журмыг төрийн захиргааны байгууллага тогтоож, жагсаалтыг Тагнуулын ерөнхий газарт бүртгүүлнэ.

25.5. Суурь бүтэц эзэмшигч нь байгалийн гамшиг, гал түймэр, осол, сүйрэл, гологдлын хор уршгийг арилгах зориулалтын техник хэрэгсэл бүхий сэргээн босгох болон гал унтраах галт тэрэгтэй байх бөгөөд тэдгээрийг байнгын бэлэн байдалтай байлгах үүрэгтэй.

25.6. Төмөр замын байгууллага, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч нь төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд саад учруулах байгалийн гамшиг, осол, сүйрэл, гологдлын хор уршгийг арилгах талаар шуурхай арга хэмжээ авах үүрэгтэй.

25.7. Хүний амь нас, эрүүл мэнд, ачаа, тээш, ачаан тээш, хөдөлгөөний аюулгүй байдалд хохирол учруулах нөхцөл байдлын үр дагаврыг

арилгахад холбогдох төрийн захиргааны болон орон нутгийн эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж, иргэн туслах үүрэгтэй.

25.8. Төмөр замын байгууллага, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч болон байгалийн гамшиг, осол, сүйрэл, гологдлын хор уршгийг арилгах үүрэгтэй холбогдох төрийн захиргааны байгууллагаас бусад байгууллага, иргэн энэ хуулийн 25.7-д заасан үүргээ хэрэгжүүлэхэд гаргасан зардал, хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу төмөр замын байгууллагаас нөхөн гаргуулах эрхтэй.

## **26 дугаар зүйл. Аюултай ачааны тээвэрлэлт, аюултай байгууламжийн ашиглалт, хамгаалалт**

26.1. Аюултай ачааны үйлдвэрлэл, хадгалалт, ачилт, буулгалт, дамжуулалт хийж байгаа газрын барилга байгууламжууд /цаашид "аюултай байгууламжууд" гэх/ нь суурь бүтцээс аюулгүй ажиллагааг хангахуйц зайд байрлах бөгөөд аюултай байгууламж байрлуулах зай, огтлолцлын болон байршлын нөхцөлийг тодорхойлох журмыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

26.2. Аюултай байгууламж эзэмшигч нь түүний аюулгүй ажиллагааг хариуцаж, аюултай байгууламжтай холбоотой осол, гэмтэл гарсан тохиолдолд суурь бүтэц эзэмшигчид нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

26.3. Аюултай ачааг төмөр замаар тээвэрлэхэд бэлтгэх, ачих, буулгах үеийн аюулгүй байдлыг ачаа илгээгч болон ачаа хүлээн авагч хангана.

26.4. Аюултай ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагааны үед гарсан осол, сүйрэл, гологдлын хор уршгийг арилгахад суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нь өөрийн галын болон сэргээн босголтын хэрэгслийг ашиглан оролцох үүрэгтэй.

## **27 дугаар зүйл. Төмөр замын зурвас газар, аюултай болон аюулгүйн бүс тэдгээрийн дэглэм**

27.1. Төмөр замын зурвас газрын хэмжээг энэ хууль болон газрын тухай хууль тогтоомжийг үндэслэн тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, төслийн баримт бичгийг харгалзан тодорхойлно.

27.2. Төмөр замын зурвас газрын болон аюулгүйн бүсийн дэглэм, хэмжээг хот байгуулалт, төмөр замын тээврийн аюулгүй байдлын нөхцөл шаардлагыг харгалзан Засгийн газар тогтооно.

27.3. Төмөр замын зурвас газрыг суурь бүтэц эзэмшигч тодорхой нөхцөл, хугацаа, төлбөртэйгээр ашиглана.

27.4. Төмөр замын зурвас газарт байгаа мод, бут, өвс, ургамал нь тээврийн аюулгүй байдалд саад учруулахаар бол төмөр замын байгууллага тэдгээрийг шилжүүлэн суулгах, тайрах, огтлох, хадах, түймэр гаргахгүйгээр шатаах зэргээр аюулгүй байдлын нөхцөлийг хангана.

27.5. Төмөр замын зурвас газар, аюултай бүсэд төмөр замын байгууллага, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч болон дайвар үйлчлүүлэгч хаалт, хамгаалалт хийнэ.

27.6. Төмөр замын зурвас газарт энэ хуулийн дагуу тогтоосон дэглэмд зааснаас бусад ажил, үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

27.7. Төмөр замын байгууллага нь төмөр замын зурвас газарт хамаарах сул, чөлөөтэй газрыг газар тариалан, зорчигч үйлчилгээ, шатамхай болон аюултай ачаанаас бусад ачааг хадгалах, буулгах, үйлчилгээ эрхлэх болон бусад зориулалтаар төмөр замын тээврийн аюулгүй байдлын шаардлагад чанд нийцүүлэн иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлэн ашиглуулж болно.

27.8. Аюултай бүсийн дэглэмийг төрийн захиргааны байгууллага тогтооно.

27.9. Төмөр замын зурвас газар, аюултай болон аюулгүйн бүс нь бусад тусгай дэглэм бүхий газруудтай давхардаж байгаа бол тухайн газарт тэдгээрийн талаар тогтоосон хамгийн хатуу дэглэм үйлчилнэ.

27.10. Төмөр замын зурвас газраас гаднах аюулгүйн бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулах, аливаа үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг тухайн нутаг дэвсгэрийн Засаг дарга аюулгүй байдлын талаар гаргасан зөвлөмж, дүгнэлтийг харгалзан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн олгоно.

## **28 дугаар зүйл. Төмөр замын гармыг ашиглах дэглэм**

28.1. Төмөр замын гармыг нээх, ашиглах, хаах, хамгаалалтын дохио, тэмдэг, төхөөрөмжөөр тоноглох, засварлах, түүнчлэн төмөр замын гармын зэрэглэл тогтоох журмыг төрийн захиргааны төв байгууллага цагдаагийн байгууллагатай зөвшилцөн батална.

28.2. Төмөр замын гармын байршлыг тогтоохдоо нутгийн өөрөө удирдах байгууллага болон төмөр замын байгууллагын саналыг харгалзана.

28.3. Төмөр замын гармын хэвийн ажиллагаа, ашиглалт, үйлчилгээ, аюулгүй байдлыг суурь бүтэц эзэмшигч хариуцна.

28.4. Гинжит машин механизм, овортой ачаа бүхий авто тээврийн хэрэгслийг төмөр замын гармаар гаргахдаа тухайн гармыг хариуцсан суурь бүтэц эзэмшигчийн зөвшөөрлөөр түүний томилсон ажилтны хяналтын дор гүйцэтгэнэ.

28.5. Төмөр замыг төмөр замын бусад шугам болон авто замтай ижил бус түвшинд огтлолцуулах шаардлагатай бол ийнхүү ижил бус түвшинд огтлолцуулах үүргийг шинээр буюу сүүлд зам тавьж байгаа этгээд хүлээнэ.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Төмөр замын байгууллагын ажилтны хөдөлмөр зохицуулалт, нийгмийн баталгаа

#### 29 дүгээр зүйл. Төмөр замын байгууллагын ажилтны хөдөлмөрийн нөхцөл

29.1. Төмөр замын байгууллагын ажилтны хөдөлмөр зохицуулалт, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн баталгааг энэ хууль, Хөдөлмөрийн тухай хууль<sup>2</sup>, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, хамтын болон хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна.

29.2. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн зохион байгуулагч, тээвэрлэлтийн үйлчилгээний ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ дүрэмт хувцас хэрэглэнэ.

29.3. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилд зохих сургалтад хамрагдаж, тухайн ажлыг гүйцэтгэх эрх авсан, эрүүл мэндийн хувьд тэнцсэн, 18 насанд хүрсэн иргэнийг ажиллуулна.

29.4. Эрүүл мэндийн үзлэг хийх хугацаа, журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

29.5. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой, аюултай бүсэд ажиллаж, галт тэргэнд хяналт, шалгалт хийж байгаа төмөр замын техник хэрэгслийг турших ажилд оролцогч ажилтан нь ажил олгогчийн зардлаар гэнэтийн ослын даатгалд заавал хамрагдана.

29.6. Энэ хуулийн 29.5-д заасан гэнэтийн ослын даатгалд хамрагдаагүйгээс учирсан хохирлыг ажил олгогч хариуцна.

#### 30 дугаар зүйл. Төмөр замын байгууллагын ажилтны хөдөлмөрийн сахилга

30.1. Төмөр замын байгууллагын ажилтны хөдөлмөрийн сахилгыг Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна.

30.2. Төмөр замын байгууллагын захиргаа хөдөлмөрийн сахилга зөрчсөн ажилтанд дараахь сахилгын шийтгэл ногдуулна:

30.2.1. сануулах;

30.2.2. үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

30.2.3. төмөр замын хөдөлгөөний бус ажилд 1 жил хүртэл хугацаагаар шилжүүлэх;

30.2.4. ажлаас халах.

#### 31 дүгээр зүйл. Төмөр замын байгууллагын ажилтны нийгмийн баталгаа

31.1. Төмөр замын байгууллагын ажилтан дор дурдсан нийгмийн баталгаагаар хангагдана:

31.1.1. төмөр замын байгууллагад тасралтгүй 25-аас доошгүй жил ажилласан эрэгтэй, 20-иос доошгүй жил ажилласан эмэгтэй төмөр замын байгууллагаас тэтгэвэр тогтоолгосон бол зургаан сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж авах;

31.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрийн дотор төмөр замаар аялах тохиолдолд жилд хийх нэг удаагийн аяллын ирэх, очих замд галт тэргээр үнэгүй зорчих.

31.2. Төмөр замын байгууллагын ажилтан хууль тогтоомжид заасан нийгмийн бусад баталгааг эдэлнэ.

31.3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос шалтгаалсан өвчний улмаас нас барсан ажилтны ар гэрт Хөдөлмөрийн тухай хуулийн 97.1.2-т заасны дагуу нөхөн төлбөр олгоно.

31.4. Энэ хуулийн 31.1, 31.3-т заасан нийгмийн баталгаатай холбогдон гарах зардлыг төмөр замын байгууллага хариуцна.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### Төмөр замын тээврийн зохион байгуулалтын бусад асуудал

#### 32 дугаар зүйл. Төмөр замын тээвэр дэх даатгал

32.1. Зорчигч галт тэргээр явахдаа гэнэтийн ослын даатгалд хамрагдах үүрэгтэй.

32.2. Төмөр замын объект, төмөр замаар тээвэрлэх ачаа, тээш, ачаан тээшийг хууль тогтоомжид заасан журмаар даатгалд хамруулж болно.

#### 33 дугаар зүйл. Төмөр замын тээвэрт хэрэглэх хэл

33.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төмөр замын байгууллага

<sup>2</sup> Хөдөлмөрийн тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн

нь өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран төмөр замын тээврийн үйл ажиллагаа эрхлэх, албан хэрэг хөтлөхдөө төрийн албан ёсны хэлийг хэрэглэнэ.

33.2.Төмөр замын өртөө, буудал, бусад газарт зорчигч болон ачаа илгээгч, хүлээн авагчид шаардлагатай мэдээллийг төрийн албан ёсны хэлнээс гадна өөр хэлээр хүргэж болно.

## НАЙМДУГААР БҮЛЭГ

**Төмөр замын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

**34 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

34.1.Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

34.1.1.төмөр замын тээврийн аюулгүй ажиллагааны журам зөрчсөн, төмөр замын тээврийн улсын хяналтын байцаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй төмөр замын байгууллага, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигчийг 10.000-30.000 төгрөгөөр, буруутай албан тушаалтан, ажилтныг 5.000-10.000 төгрөгөөр торгох;

34.1.2.төмөр замын осол, сүйрэл, гологдлоос сэргийлэх арга хэмжээг зохих ёсоор аваагүй, төмөр замын ажилтанд зааварчилгааг тогтоосон журмын дагуу өгөөгүй бол төмөр замын байгууллага, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигчийг 20.000-50.000 төгрөгөөр, буруутай албан тушаалтан, ажилтныг 5.000-15.000 төгрөгөөр торгох;

34.1.3.энэ хуулийн 34.1.1, 34.1.2-т заасан зөрчлийг удаа дараа гаргасан, төмөр замын тээврийн аюулгүй байдлын журмыг ноцтой зөрчиж, хүний амь нас эрсэдсэн осол, төмөр замын хэвийн үйл ажиллагааг удаан хугацаагаар алдагдуулсан сүйрэл гарахад хүргэсэн төмөр замын байгууллага, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигчийн тусгай зөвшөөрөл, гэрчилгээг хүчингүй болгох, эсхүл хүчингүй болгохгүйгээр 50.000-250.000 төгрөгөөр, буруутай

албан тушаалтан, ажилтныг 10.000-50.000 төгрөгөөр торгох;

34.1.4. төмөр замын зурвас газрын дэглэм зөрчсөн бол аж ахуйн нэгж, байгууллагыг 50.000-150.000, иргэнийг 10.000-30.000 төгрөгөөр торгох;

34.1.5.төмөр замын аюултай бүсийн хамгаалалтыг хэрэгжүүлээгүй бол төмөр замын байгууллагыг 10.000-30.000 төгрөгөөр, буруутай албан тушаалтан, ажилтныг 5.000-15.000 төгрөгөөр торгох;

34.1.6.төмөр замын аюултай бүсийн хамгаалалтын арга хэмжээг зохих ёсоор аваагүйгээс осол, гологдол гаргасан бол төмөр замын байгууллагыг 100.000-250.000 төгрөгөөр, буруутай албан тушаалтан, ажилтныг 20.000-50.000 төгрөгөөр торгох;

34.1.7.төмөр замын аюулгүйн бүсийн дэглэм зөрчсөн байгууллага, аж ахуйн нэгжийг 50.000-100.000 төгрөгөөр, иргэнийг 10.000-30.000 төгрөгөөр торгох;

34.1.8.энэ хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр тодорхойлсон тээвэр, үйлчилгээний журам зөрчсөн төмөр замын байгууллага, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигчийг 50.000-100.000 төгрөгөөр, албан тушаалтныг 10.000-25.000 төгрөгөөр торгох;

34.1.9.энэ хуулийн 18, 19, 20, 21 дүгээр зүйлд заасан үүргээ биелүүлээгүй төмөр замын байгууллага, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч болон төмөр замын тээврийн үйлчилгээ, хөдөлгөөний аюулгүй байдал, техникийн стандарт шаардлагатай холбоотой хууль тогтоомж зөрчсөн төмөр замын бус байгууллага, аж ахуйн нэгжийг 50.000-100.000 төгрөгөөр, тэдгээрийн буруутай албан тушаалтныг 10.000-50.000 төгрөгөөр, иргэнийг 2.000-5.000 төгрөгөөр торгох;

34.1.10.энэ хуулийн 34.1.9-д заасан зөрчлийг удаа дараа гаргасан, эсхүл ноцтой зөрчил гаргасан бол аж ахуйн нэгж, байгууллагыг 150.000-250.000 төгрөгөөр, тэдгээрийн буруутай албан тушаалтан, ажилтныг 30.000-50.000 төгрөгөөр, иргэнийг 10.000-30.000 төгрөгөөр торгох.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

### АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15 дахь хэсэгт "15.15.11. төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах." гэсэн заалт нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.15.1, 15.15.3 дахь заалтыг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:





1/ "15.15.1. төмөр замын суурь бүтэц барих, ашиглах;" ;

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төмөр замын тээврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2/ "15.15.3. төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх;" ;

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1996 оны 5 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хуулийг 2007 оны 7 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан Төмөр замын тээврийн тухай

хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 08 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

### НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "5.1.13. Шинэ ургацын

өдрүүд: 9 дүгээр сарын 5-наас 10 дугаар сарын 20." гэсэн заалт нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 08 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

### БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ОЛОН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГААГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН 1999 ОНЫ ЖЕНЕВИЙН АКТАД НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Бүтээгдэхүүний загварын олон улсын бүртгэлийн Гаагийн хэлэлцээрийн 1999 оны Женевийн актad Монгол Улс нэгдэн орсныг Засгийн газрын

өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 07 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

### Тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 14.8-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Хурлын тогтоолын төсөлд тусгагдсан шинэ ургацын өдрүүдийг зохион байгуулах журмыг батлах асуудал нь Засгийн газрын шийдвэрээр зохицуулах боломжтой байх тул төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

1. Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл, С.Баярцогт, Р.Нямсүрэн, Н.Энхболд нараас 2007 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Журам батлах тухай" Улсын Их

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

 2007 оны 07 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 54

 Улаанбаатар  
хот

### Төсвийн хүрээний мэдэгдлийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 6.1.2 дахь заалт, 25 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2008 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2009-2010 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтүүдийн хязгаарыг 1 дүгээр хавсралтаар, Засгийн газрын 2008-2010 оны дунд хугацааны зорилтуудыг 2 дугаар хавсралтаар тус тус зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, Монгол Улсын 2008

оны төсвийн тухай хуулийн төслийг энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар зөвшөөрсөн үндсэн үзүүлэлтүүдийн хязгаарыг баримтлан боловсруулахыг Монгол Улсын Засгийн газар /М.Энхболд/-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг УИХ-ын Төсвийн байнгын хороо /Ч.Улаан/, Эдийн засгийн байнгын хороо /Д.Ганхуяг/-нд даалгасугай.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН

Монгол Улсын Их Хурлын 2007 оны  
7 дугаар сарын 27-ны өдрийн 54 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

### МОНГОЛ УЛСЫН 2008 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2009-2010 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХЯЗГААР

	Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	2008 он	Төсөөлөл	
			2009 он	2010 он
1.	ДНБ-ий бодит өсөлтийн доод хэмжээ, хувь	8,7	9,2	14,6
2.	Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн өсөлтийн дээд хэмжээ, хувь	5,0	5,0	5,0
	<b>ДНБ-д эзлэх хувиар</b>			
3	Төсвийн нийт орлогын дээд хэмжээ	40,2	41,8	40,1
4	Төсвийн нийт зарлагын дээд хэмжээ	43,2	44,9	43,2
5	Төсвийн урсгал тэнцлийн доод хэмжээ	8,2	8,2	7,6
6	Төсвийн алдагдлын дээд хэмжээ	-3,0	-3,0	-3,0
7	Хөрөнгийн зардлын доод хэмжээ	7,8	7,8	7,8

Улсын Их Хурлын 2007 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 54 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2008-2010 ОНЫ ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТУУД

Монгол Улсын Засгийн газар дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг эрс нэмэгдүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бататгах, инфляцийг зохистой түвшинд байлгах, улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хэрэглээг урамшуулах, уул, уурхайн салбарын хөгжлийг түргэтгэх замаар эдийн засгийн тэлэх бодлого баримтална. Эдийн засгийн бодлого нь өсөлтийг урамшуулж, төсвийн орлого, гадаад зээлийн ашиглалтыг зохистой нэмэгдүүлэн, нийгмийн бодлого, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх замаар ард иргэдийнхээ амьжиргааны түвшинг дээшлүүлж сайн сайхан аж байдлыг хангах, ядуурал, ажилгүйдлийг бууруулах зорилтыг хангахад чиглэгдэж байна.

### Нэг, Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгална.

1.1. Эдийн засгийн бодит өсөлтийг дунд хугацаанд 8.7-14.6 хувиас бууруулахгүй байх.

1.2. Инфляцийн түвшинг дунд хугацаанд 5 хувиас хэтрүүлэхгүй байлгах зохихуулалтыг Монголбанкттай хамтран хэрэгжүүлэх.

1.3. Төлбөрийн тэнцлийн урсгал тэнцлийн алдагдлыг багасгаж гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх.

1.4. Санхүүгийн салбарыг эрсдлээс хамгаалах механизмыг бүрдүүлэх, даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, санхүүгийн тайлангийн олон улсын стандартыг нэвтрүүлэх.

### Хоёр, Төсвийн тогтвортой байдлыг хадгална.

2.1. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн орлого, зарлагын харьцааг бууруулах зарчим баримтлах.

2.2. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг эдийн засгийн өсөлт, инфляцитай уялдуулан жил бүр 20 хувиас багагүй хэмжээгээр нэмэгдүүлэх.

2.3. Хөнгөлөлттэй зээлийг авто замын сүлжээг хөгжүүлэх, эрчим хүчний шинэ эх үүсвэр барьж байгуулах, импортын нефть бүтээгдэхүүнийг орлуулах бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хот, суурин газрын агаарын бохирдлыг багасгахад чиглэгдсэн бүтээн байгуулалтын ажилд түлхүү ашиглах.

2.4. Уул, уурхайн салбарын орлогоос Монгол Улсын хүртэх хувийг хөрөнгө оруулагч болон Монгол Улсын ашиг сонирхолд харилцан нийцтэй байхаар тогтоож, хуримтлуулан зарцуулах.

### Гурав, Бодит салбарын хөгжлийг эрчимжүүлж, эдийн засагт үзүүлэх нөлөөг нэмэгдүүлнэ.

3.1. Мянганы зам болон Азийн авто замын сүлжээнд холбогдох нэгдсэн авто зам барих ажлыг эрчимжүүлэх.

3.2. Хувийн хэвшлийн хөгжлийг эдийн засгийн бүхий л хөшүүргээр дэмжих, шинжлэх ухаан технологийн дэвшлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, технологийн шинэчлэл хийх, шинэ технологид тулгуурласан үйлдвэрлэл, бүтээгдэхүүн бий болгохыг дэмжих.

3.3. Улсын болоод хувийн хэвшлийн хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэр, аж ахуйн нэгж байгуулах замаар хувийн хэвшлийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих.

3.4. Усалгаатай газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүн амыг ундны цэвэр усаар хангах ажлын хүрээнд хөдөө орон нутагт инженерийн худаг гаргах ажлыг өргөжүүлэх.

3.5. Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгож, эрчимжсэн мал аж ахуйг бүсчлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар чанартай, аюулгүй түүхий эд, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүнсний хангамжийг сайжруулах.

3.6. Бүх айл, өрхийг цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй болгох, тээврийн дэд бүтцийг сайжруулахад улсын хөрөнгө оруулалтыг түлхүү чиглүүлэх.

3.7. Нүүрсэнд боловсруулалт хийж хорт хийн агууламжийг багасгах, түлшинд хэрэглэх технологийг нэвтрүүлж агаарын бохирдлыг бууруулах.

3.8. Дечин мянган айлын орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын төвийн гэр хорооллуудыг олон нийтийн оролцоотойгоор дахин төлөвлөлт хийж замаар орон сууцны хороолол болгон төвлөрсөн инженерийн хангамжид холбох, бүсийн тулгуур төвүүдийн дулаан, цэвэр, бохир усны шугам

сүлжээ, инженерийн байгууламжуудад иж бүрэн шинэчлэлт хийж, эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.

**Дөрөв. Уул уурхайн салбарт баримтлах бодлого нь улсын хөгжлийн стратеги, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдана.**

4.1. Уул, уурхайн салбараас улсын төсөвт орох орлогыг цаашид эдийн засгийн өндөр өсөлтийг хангах арга хэрэгсэл болгож ашиглах.

4.2. Эрдэс баялгийн салбарыг зөв зохистой хөгжүүлж, түүний эдийн засаг, улсын төсөвт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэн уул уурхайн салбарын орлогын эзлэх хувийг 2008-2010 онд ойролцоогоор 30-40 хувьд хүргэн Монгол Улсын хөгжлийн санг бүрдүүлэх.

4.3. Экспортод гаргаж буй эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнийг дэлхийн жишигт ойртуулж, зөв гольдролд оруулах.

4.4. Шинээр ашиглалтад орохоор төлөвлөгдөж буй Дорнод аймгийн Улааны хар тугалга цайрын орд, Сэлэнгэ аймгийн Гацууртын алтны ордыг 2008 онд, Оюу-толгойн зэсийн ордын ил уурхайн хэсэг, Таван толгойн нүүрсний ордыг 2010 онд тус тус ашиглалтад оруулах.

**Тав. Нийгмийн эмзэг хэсэгт түлхүү хандсан, ядуурлыг бууруулах, хүний хөгжлийг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.**

5.1. Улсын төсвөөр дамжин хүн амд хуваарилагдах орлогын хэмжээг нэмэгдүүлж, үр ашгийг дээшлүүлэх.

5.2. Гадаадын буцалтгүй тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад түншүүдтэй идэвхитэй хамтран ажиллах.

5.3. Дархлаажуулалтыг эрчимжүүлэх, ХДХВ, ДОХ, сүрьеэгээс сэргийлэх, сургууль, соёлын байгууллагуудын хүртээмж, нөхцөлийг сайжруулах, мэргэжлийн сургалтын байгууллагуудыг бий болгоход гадаад тусламжийн зарим хэсгийг ашиглах.

5.4. Хүүхэд, эхчүүдийн хоол, тэжээлийн дутагдлыг арилгах, хүүхдийн өсөлт, оюуны

чадамжийг сайжруулах, сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх, эх, нялхсын эндэгдлийг багасгахад чиглэсэн хөтөлбөрүүдийг дэмжих.

5.5. Хүн амын өсөлтийг урамшуулах, хөдөлмөрийн зах зээлийг үр ашигтай зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хөгжүүлэх замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг сайжруулах.

5.6. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн сургалтын төвүүдийг шинэ тоног төхөөрөмж, техник хэрэгслээр тоноглож, сургалтын орчинг шинэчлэх.

5.7. Хүүхэд залуучуудын бие бялдрыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан спорт, соёлын байгууллагын материаллаг баазыг сайжруулах.

5.8. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 304 дүгээр зарлигаар батлагдсан "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх.

**Зургаа. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг сайжруулна.**

6.1. Төрийн захиргааны болон төсөвт байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулсан байдалтай уялдуулан үр дүнгээр санхүүжүүлэх бодлогыг үргэлжлүүлэх.

6.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бүтцийг үе шаттай боловсронгуй болгох, орон нутгийн бие даасан байдлыг хангах, нутгийн захиргааны байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх.

6.3. Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний чанар, хүртээмжид төрийн хяналтын байгууллагаас илүүтэйгээр төрийн бус байгууллагууд, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх, ил тод байлгах бодлогыг баримтлах, төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг өргөжүүлэх.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 265958  
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 2.5